

УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН АРИЛЖАА ТӨЛБӨР, ТООЦОО ХИЙХ ЕРӨНХИЙ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмаар Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-оос уул уурхайн бүтээгдэхүүний бирж /цаашид “Бирж” гэх/-ийн арилжаа, төлбөр тооцоо, уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны хэлцлийн үр дүнд үүсэх тооцоог боловсруулан баталгаажуулах, төлбөр гүйцэтгэх даалгаврыг эрх бүхий төлбөрийн байгууллагад илгээх, төлбөрийн эрсдэлийг системийн хэмжээнд удирдах, тооцооны үйл ажиллагаанд оролцогч талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулна.

1.2.Энэ журмын 2.1.1, 2.1.2-т заасан гэрээг энэ журмаар, 2.1.3, 2.1.4-т заасан гэрээг Хорооны “Зохицуулалттай зах зээлд арилжих үүсмэл санхүүгийн хэрэгслийн ерөнхий журам”-аар зохицуулна.

1.3.Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаа зохион байгуулах, төлбөр тооцоо гүйцэтгэхтэй холбоотой нарийвчилсан харилцааг бирж, төлбөр, тооцооны байгууллагуудын баталсан журмаар зохицуулна.

Хоёр.Биржийн арилжааны төрөл, хэлбэр

2.1.Биржийн цахим арилжаагаар дараах төрлийн гэрээг арилжина. Үүнд:

- 2.1.1.спот гэрээ;
- 2.1.2.форвард гэрээ;
- 2.1.3.фьючерс гэрээ;
- 2.1.4.опцион гэрээ.

2.2.Биржээр арилжаалах спот гэрээний хувьд дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:

- 2.2.1.бүтээгдэхүүнийг тогтоосон үнээр шууд, биет байдлаар нийлүүлэх;
- 2.2.2.уул уурхайн бүтээгдэхүүн нийлүүлэх хугацаа 30 хоногоос дээшгүй байх,
- 2.2.3.Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 12.6-д заасны дагуу спот гэрээгээр арилжаалах бүтээгдэхүүн нь биржийн итгэмжлэгдсэн агуулах, терминалд байршиж, бүртгэгдсэн байх.
- 2.2.4.худалдан авагч тал тодорхой байх

2.3.Биржээр арилжаалах форвард гэрээний хувьд дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:

- 2.3.1.тогтоосон хугацаанд, тохиролцсон нөхцөлөөр, биет байдлаар ирээдүйд нийлүүлэх;
- 2.3.3.худалдан авагч тал тодорхой байх.

Гурав.Биржийн эрх, үүрэг

3.2.Бирж нь уул уурхайн бүтээгдэхүүний цахим арилжааг нээлттэй, ил тод, оролцогчдын тэгш эрхийг хангасан байдлаар зохион байгуулж, зах зээлийн бодит үнэ тогтоох, арилжаалагдаж буй уул уурхайн бүтээгдэхүүний үнэ, гэрээний мэдээллийг арилжаанд оролцогчид болон олон нийтэд үнэн зөв, түргэн шуурхай хүргэх нөхцөлийг хангаж ажиллана.

3.3.Бирж нь уул уурхайн бүтээгдэхүүний стандарт гэрээний нөхцөл, шаардлагыг тогтоож, хяналт тавьж, мөрдүүлэх үүрэгтэй.

3.4.Биржээр арилжаалсан уул уурхайн бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу баталгаажуулна.

3.5.Бирж нь уул уурхайн бүтээгдэхүүний арилжаатай холбоотой зах зээлийг урвуулан ашиглах, үнэ ханшийг зохиомлоор өсгөх, бууруулах, төлбөр тооцооны системд доголдол үүсэх зэрэг эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор арилжааны бодит цагийн хяналт тавих үүрэгтэй.

3.7.Бирж нь ашиг сонирхлын зөрчил үүссэн, зах зээлийг урвуулан ашигласан тохиолдолд холбогдох нотлох баримт гаргах чиглэлээр арилжаатай холбоотой мэдээллийг хадгалж, бүртгэл хөтлөх үүрэгтэй.

3.8.Бирж нь гэрээнд заасан хүргэлт хийх хугацаанд биетээр хүргэх суурь хэрэгслийн нийлүүлэлтийн тоо хэмжээг тооцоолж гаргана.

Дөрөв.Тооцооны байгууллагын эрх, үүрэг

4.1.Тооцооны байгууллага нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална. Үүнд:

4.1.1.ил тод засаглалтай байх ба санхүүгийн зах зээлийн найдвартай, үр ашигтай байдлыг дэмжих, санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангах, зах зээлд оролцогчдын эрх ашгийг хамгаалах;

4.1.2.төлбөр түргэн гүйцэтгэх, үйл ажиллагааны, төлбөрийн чадварын болон бусад эрсдэлийг иж бүрэн удирдах эрсдэлийн удирдлагын тогтолцоотой байх;

4.1.3.тооцооны үйл ажиллагаатай холбоотой оролцогчдын төлбөрийн чадварын эрсдэлийг тооцоолох, хянах, удирдах, тооцооны гишүүн бүрийн төлбөрийн чадварын эрсдэлийг хаах, барагдуулах хангалттай хэмжээний санхүүгийн эх үүсвэртэй байх;

4.2.Тооцооны байгууллага нь маржингийн тооцооллын үндсэн дээр эрсдэлийг бууруулах зорилгоор тооцооны гишүүнээс барьцаа шаардах эрхтэй бөгөөд маржинг тооцоолох эрсдэлд суурилсан тусгай аргачлал, загварыг баталж үйл ажиллагаандаа мөрдөнө.

4.3.Тооцооны байгууллага нь төлбөрийн чадварын эрсдэлийг бууруулах, удирдах зорилгоор тооцооны гишүүн эсхүл харилцагчаас маржин болон бусад хэлбэрээр барьцаа байршуулахыг шаардах эрхтэй.

4.4.Тооцооны байгууллагын тооцоолсон маржингийн дүнгээр төлбөр гүйцэтгэх байгууллагад тооцооны гишүүний байршуулах хөрөнгийг маржин гэх бөгөөд тооцооны гишүүн нь арилжаа эхлэх цагаас 30 минутын өмнө 15 хүртэлх хувийн маржинг тооцооны байгууллагын дансанд байршуулсан байна.

4.5.Тооцооны байгууллага нь тооцооны гишүүн эсхүл харилцагчийн маржин хэлбэрээр байршуулсан барьцаа хөрөнгийг харилцагч тус бүрээр, өөрийн хөрөнгөөс тусдаа хадгалах бөгөөд зөвхөн тухайн тооцооны гишүүн, харилцагчийн төлбөрийн үүргийг баталгаажуулах, гүйцэтгэхэд ашиглана.

4.6.Тооцооны байгууллагын гишүүнчлэлийн шаардлага, шалгуурыг хангасан зохицуулалттай этгээдийг тооцооны байгууллагын гишүүнээр бүртгэнэ.

4.7.Тооцооны байгууллага нь уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаатай холбоотой үүсэх системийн эрсдэлийг удирдах үүрэгтэй.

4.8.Биржийн арилжаанд оролцогч нь төлбөр тооцоо хийх явцад гэрээг зөрчсөн тохиолдолд тооцооны байгууллага нь төлбөр тооцоонд оролцогчдын байршуулсан маржин, төлбөрийн баталгааны санд байршуулсан хөрөнгийг ашиглана.

Тав.Төлбөрийн байгууллагын эрх, үүрэг

5.1.Төлбөрийн байгууллага нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

5.1.1.тооцооны байгууллагаас ирүүлсэн даалгаврын дагуу худалдан авагчаас төлөх төлбөрийг худалдагчийн дансанд шилжүүлэх;

5.1.2.төлбөр төлөгдсөн тайлангийн дагуу зохих санхүүгийн бүртгэлийг гүйцэтгэн гүйлгээг баталгаажуулах;

5.1.3.арилжааны төлбөрийн гүйлгээг тухайн арилжаа явагдсанаас хойш гэрээнд заасан нөхцөлийн дагуу гүйцэтгэнэ.

Зургаа.Эрсдэлийн удирдлага

6.1.Тооцооны үйл ажиллагаанаас санхүүгийн системд үүсч болзошгүй эрсдэлээс хамгаалах зорилгоор тооцооны байгууллага нь эрсдэлийн санг байгуулна.

6.2.Тооцооны байгууллага нь эрсдэлээс хамгаалах санг хувь нийлүүлсэн хөрөнгийн 20 хувиас доошгүй хувьтай тэнцэх мөнгөн хөрөнгөөр байгуулна.

6.3.Эрсдэлийн сангийн хөрөнгийг зөвхөн онцгой нөхцөл байдал үүсэх, өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас тооцооны гишүүдэд учруулсан хохирлыг барагдуулах, тооцооны байгууллагын гишүүд төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд зах зээлд учирсан эрсдэлийг хаах зорилгоор зарцуулна.

6.4.Эрсдэлийн сангийн хөрөнгийг арилжааны банкинд тусгайлсан данс нээж байршуулах бөгөөд сангийн зарцуулалт, үлдэгдлийг улирал тутам Хороонд хүргүүлнэ.

6.5.Тооцооны байгууллага нь эрсдэлийн удирдлагын нэгжтэй байх бөгөөд тус нэгж нь зах зээлд оролцогчдын төлбөрийн чадварыг тодорхойлох, эрсдэлийг үнэлэх, эрсдэлийг удирдах дараах үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

6.5.1.тооцооны үйл ажиллагаанд учирч болох /зах зээлийн эрсдэл, төлбөрийн чадварын эрсдэл, үйл ажиллагааны эрсдэл, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэл/ эрсдэлийн удирдлага, бодлогыг боловсруулж мөрдөх;

6.5.2.тооцооны байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй явуулах төлөвлөгөөтэй байх;

6.5.3.уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тогтолцооны эрсдэлийг шинжилж, эрсдэлийг бууруулах арга хэмжээний талаарх зөвлөмжөөр бирж, төлбөрийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий байгууллагыг хангах;

6.5.4.тооцооны гишүүдийн барьцааны шаардлага, маржинг тооцооны өдөр бүр тооцоолох бөгөөд маржин болон барьцааны хувь хэмжээг төлбөрийн чадварын эрсдэлтэй уялдуулж тогтоох;

6.5.5.тооцооны гишүүдийн төлбөрийн чадварын эрсдэлийг удирдахын тулд эрсдэл багатай барьцааг хүлээн зөвшөөрч, үнэ цэнийн бууралт, төвлөрлийн хязгаар зэргийг харгалзан тогтоох;

6.5.6.тооцооны үйл ажиллагааны эрсдэл, түүнээс гарсан алдагдлын талаарх мэдээллийг бүртгэх, хадгалах;

6.5.7.олон улсын жишигт нийцсэн эрсдэлийн үнэлгээ, стресс тест зэрэг тоон болон чанарын аргачлал, зөвлөмжийг гаргаж, оролцогчдын төлбөрийн эрсдэлийг бууруулах бодлогыг баримтлана.

Долоо.Бусад

7.1.Арилжаа, төлбөр тооцоотой холбоотой үүсэх эрх, үүрэгтэй холбогдон гарсан маргааныг эрх бүхий байгууллага хянан хэлэлцэж шийдвэрлэх бөгөөд уг шийдвэрийг эс зөвшөөрвөл талууд шүүхэд гомдол гаргаж болно.

~000~